

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 2 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 3 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1, 271¹.1.2 дахь заалт, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Мэргэжлийн зөвлөлийн хуралдааны 2021 оны 08/06 тоот шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлох журам"-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.
- 2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2008 оны 692 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
- 3.Барааны ангиллын кодыг урьдчилан тодорхойлсон шийдвэр гаргахтай холбоотой програм боловсруулж нэвтрүүлэх, сан үүсгэх, хөтлөх ажлыг зохион байгуулахыг Гаалийн ерөнхий газрын Гаалийн бүрдүүлэлтийн газар /Д.Зоригоо/, Мэдээллийн технологийн төв /Б.Ганзориг/-д тус тус үүрэг болгосугай.
- 4.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дэд дарга /Ц.Гэндэнцэвээн/-д даалгасугай.

ДАРГА Б.АСРАЛТ